

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 11 ДҮГЭЭР САРЫН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**


2025 оны 12 дугаар сарын 03

Улаанбаатар хот

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх, үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх, үйлчилгээг сайжруулах, удирдлагыг мэдээллээр хангах зорилгоор байгууллагын үйл ажиллагааны 11 дүгээр сарын биелэлтэд Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам”-д заасны дагуу төлөвлөгөөнд тусгагдсан 2 зорилтын 33 арга хэмжээг хамруулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Арга хэмжээний 54.5 хувь нь бүрэн хангалттай буюу 90-100 хувь, 36.3 хувь нь хангалттай буюу 85 хүртэл хувь, 9.1 хувь нь хангалтгүй буюу 70-аас доош хувьтай үнэлэгдлээ. (График 1, Хүснэгт 1)

График 1



Хүснэгт 1


Нийт арга хэмжээ	Арга хэмжээний зорилт, хэрэгжилтийн үнэлгээ (хувиар)			Хувь
	Бүрэн хангалттай	Хангалттай	Хангалтгүй	Дундаж хувь
	100 хүртэл	85 хүртэл -70-с дээш	70 хүртэл	
1	2	3	4	6
33	18	12	3	91.2

Зорилт тус бүрээр ангилан авч үзвэл Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд “Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна” зорилтод тусгагдсан 7 арга хэмжээний дундаж “бүрэн хангалттай” буюу 87.1 хувийн биелэлттэй, Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд “Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ” зорилтод тусгагдсан 26 арга хэмжээнүүдийн дундаж үнэлгээ нь “бүрэн хангалттай” буюу 92.3 хувьтай байна. (График 2, Хүснэгт 2)

Хүснэгт 2

Д/д	Нэгжийн нэр	Нийт арга хэмжээ	100%	85%	70%	50%	Дундаж хувь
1	2	3	4	5	6	7	9
1	Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна	7	1	6	-	-	87.1
2	Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ	26	17	6	2	1	92.3
Нийт		33	18	12	2	1	89.7

График 2



Чиглэл тус бүрээр авч үзвэл газар, нэгжүүд байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг эрчимжүүлэх чиглэлээр байгууллагын үйл ажиллагааны сарын төлөвлөгөөнд тусгуулаагүй үндсэн чиг үүргийн ажлыг тогтмол гүйцэтгэж байгаа нь үнэлгээ буурч байгаа шалтгаан юм.

Захиргаа, удирдлагын газар, Мэдээллийн технологийн хэлтэс төлөвлөсөн арга хэмжээнүүдийн үнэлгээ буурч үр дүнг нэмэгдүүлж, эрчимжүүлэх шаардлагатай бол бусад нэгжийн төлөвлөн хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд 85-100 хувиар үнэлэгдсэн. Үнэлгээ буурсан арга хэмжээнд:

Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах 2 арга хэмжээ байгаа нь:

- Захиргаа, удирдлагын газар-1;
- Мэдээллийн технологийн хэлтэс-2;

Хүснэгт 3

Д/д	Нэгжийн нэр	Нийт арга хэмжээ	100%	85%	70%	50%	Дундаж хувь
1	2	3	4	5	6	7	9
1	Захиргаа, удирдлагын газар	15	10	4	1	-	94
2	Виз, зөвшөөрлийн газар	2	-	2	-	-	85
3	Иргэний харьяаллын газар	1	-	1	-	-	85
4	Зөрчил шалган шийдвэрлэх газар	3	1	2	-	-	90
5	Санхүү, хангалт, үйлчилгээний газар	1	1	-	-	-	100
6	Гадаад харилцаа, судалгаа, хамтын ажиллагааны хэлтэс	2	1	1	-	-	92.5
7	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс	2	2	-	-	-	100
8	Мэдээллийн технологийн хэлтэс	3	1	-	1	1	73.3
9	Зөвлөгөө, мэдээллийн хэлтэс	2	1	1	-	-	92.5
10	Захиргаа, удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан	1	1	-	-	-	100
11	Санхүү, хангалт, үйлчилгээний газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан	1	-	1	-	-	85
Нийт		33	18	12	2	1	90.6

График 3



Мөн газар хэлтсүүдийн буюу Захиргаа, удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан 1 арга хэмжээ 100 хувь, Санхүү, хангалт, үйлчилгээний газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан 1 арга хэмжээний биелэлт 85 хувь үнэлэгдсэн байна.

Дүгнэлт, зөвлөмж

Байгууллагын 2025 оны 11 дүгээр сард төлөвлөн гүйцэтгэсэн 33 арга хэмжээний хэрэгжилт 91.2 хувьтай үнэлэгдлээ. Энэ нь өмнөх сарын үйл ажиллагааны үнэлгээнээс 2.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хэрэгжилт “хангалтгүй” буюу 70 хүртэл хувьтай үнэлэгдсэн

Хилийн боомтод виз мэдүүлэх, олгох киоск машиныг үйлчилгээнд нэвтрүүлэх (Хэрэгжилт 50 хувь)

Тус арга хэмжээ нь орон нутаг дахь газар, нэгжүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан тул эрчимжүүлж, удирдлага, зохион байгуулалтаар ханган бүрэн хэрэгжүүлж дуусгах;

Төрийн тусгай албаны гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлийн цахим хуудаст зарлах (Хэрэгжилт 70 хувь)

Мэдээллийн аюулгүй байдлын стандарт MNS ISO270001:2023 нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах хүрээнд холбогдох журмуудыг батлуулах (Хэрэгжилт 70 хувь)

Дээрх арга хэмжээнүүд нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй тул зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах;

85 хувьтай үнэлэгдсэн нийт 12 арга хэмжээ нь байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан тухайн газар, нэгжийн үндсэн чиг үүргийн ажил бөгөөд 2025 оны жилийн эцсийн үнэлгээ гараагүй тул бүрэн хангагдсан гэж үзэхгүй болно. (Хэрэгжилт 85 хувь)

3. “Бүрэн хангалттай” буюу 100 хувьтай үнэлэгдсэн 18 арга хэмжээний үр дүнг цаашид бууруулахгүйгээр чанаржуулж, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах шаардлагатай.

--oo0oo--